



Аравдугаар сар 2017 он

ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮНД ДУГААР ОЛГОХ, БҮРТГЭХ АЖИЛ ЯВАГДАЖ БАЙНА

Монгол Улсын хилээр анх удаа нэвтэрч буй болон ашиглагдаж байгаа хөдлөх бүрэлдэхүүнд дугаар олгох, бүртгэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж “Хөдлөх бүрэлдэхүүн бүртгэх, дугаар олгох журам”, “Хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалт. 2-р хэсэг. Төмөр замын ачааны вагоны дугаарлалтад тавих шаардлага MNS 6630-2:2016” стандартыг үндэслэн төвийн захирлын тушаалаар “УБТЗ” ХНН-т хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгчийн “01” тоот кодыг олгож, “УБТЗ” ХНН-ийн 192 ачааны хагас вагонд 8 оронтой шинэ дугаарыг олголоо.

“Төмөр замын зураг төслийн институт” ХХК-ийн 300 вагоны дугаар, хилээр хүлээн авсан акт, вагоны техникийн паспорт, гаалийн мэдүүлэг зэргийг шалган баталгаажуулж дээрх стандартыг үндэслэн 5 вагонд шинэ дугаар олгоод байна.



ТӨМӨР ЗАМЫН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНУУДТАЙ УУЛЗАЖ, ХУУЛИЙН ТӨСӨЛД ТУСГАХ АСУУДЛААР НЭЭЛТТЭЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 115 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2017.10.02-нд “БТЕГ” ХХК, 2017.10.06-нд Northern Railways компанитай санал солилцох уулзалт арга хэмжээ зохион байгуулж, Төмөр замын тээврийн тухай хуулийн хэрэгжилт /Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал/ -ийн дагуу хийсэн үнэлгээний тайлан танилцуулав. Уулзалтаар төмөр замын тээврийн салбарын өнөөгийн хууль, эрх зүйн орчин, тулгамдаж буй асуудлууд, тарифын тогтолцоо, түүний хяналт, хөрөнгө оруулалт, шударга өрсөлдөөн, зурвас газар, яамд болон төмөр замын байгууллага хоорондын ажлын уялдаа холбоо, салбарын бодлогын хэрэгжилт, зохицуулалт, эрдэм шинжилгээ, судалгаа зэрэг олон асуудлаар санал солилцлоо. Ажлын хэсэг 2017.10.24-27-нд “УБТЗ” ХНН-ийн Сүхбаатар, Ерөө, Дархан, Зүүнхараа, “БТЕГ” ХХК-ийн Баянгол төмөр замын Цагаан хаалга, Хандгайт, “МТЗ” ТӨХК-ийн Төмөртэй өртөөнд ажиллаж, төмөр замын байгууллагын ажилтнуудтай уулзаж, хуулийн төсөлд тусгах зайлшгүй шаардлагатай шийдвэрлэгдээгүй, зохицуулагдаагүй асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг зохион байгууллаа.



Аравдугаар сар 2017 он

СУУРЬ БҮТЭЦ ХООРОНД ГАЛТ ТЭРЭГ СОЛИЛЦОХ ТЕХНОЛОГИЙН ГОРИМЫН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛЖ БАЙНА

“УБТЗ” ХНН, “МТЗ” ТӨХК, “БТЕГ” ХХК-ийн суурь бүтэц хооронд галт тэрэг солилцох технологийн горим боловсруулах, төмөр замын сүлжээний суурь бүтэц дэх төмөр замын нийлэх өртөөдийн технологийн үйл ажиллагаатай танилцах, мэдээлэл авах зорилгоор төвийн захирлын тушаалаар 2017.10.05-06-нд “УБТЗ” ХНН-ийн Сүхбаатар хэсэглэл дэх Ерөө өртөө, “БТЕГ” ХХК-ийн Баянголын төмөр замын Цагаан хаалга болон Хандгайт өртөө, “МТЗ” ТӨХК-ийн Төмөртэй өртөөдөд томилолтоор ажиллалаа. Ерөө, Цагаан хаалга, Төмөртэй өртөөний технологийн процесс, Ерөө болон Цагаанхаалга, Хандгайт болон Төмөртэй өртөө хооронд галт тэрэг солилцох технологийн процесс, Төмөртэй өртөөний техник захирамжийн акт, салбар замд сэлгээний ажил хийх заавар, Төмөртэй–Хандгайт чиглэлийн вагон зогсолтын судалгаа зэрэг 239 хуудас баримт бичгийг бүрдүүлж суурь бүтэц хооронд галт тэрэг солилцох технологийн горимын төслийг боловсруулж байна.



ТӨВИЙН МЭРГЭЖИЛТНҮҮД ӨӨРСДИЙН АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ОНЦЛОГОО ТАНИЛЦУУЛАН АЖИЛЛАЖ БАЙНА

Төвийн захирлын үүрэг даалгаврын дагуу “Би юу хийдэг вэ?” ажил мэргэжлээ сурталчлан таниулах үйл ажиллагааны хүрээнд Технологи, мэдээлэл, сургалт, судалгааны хэлтсээс “Төмөр замын дохиолол, холбооны байгууламж”, “Судалгааны ажлын тухай”, Хөдөлгөөн зохицуулалт, хөдлөх бүрэлдэхүүний хэлтсээс “Галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн шинжилгээ”, “Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг”, “Тээврийн удирдлага, тээвэр зохион байгуулалт” сэдвээр тус тус мэдээлэл бэлтгэн, төвийн ажилтнуудад мэргэжлээ таниулан ажиллаа.





Аравдугаар сар 2017 он

“ТӨМӨР ЗАМЫН ЗАМЧИН” МЭРГЭЖЛЭЭР ЧАДАМЖИД СУУРИЛСАН СУРГАЛТЫГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Төвийн дэргэдэх “Хос зам” сургалтын төвийн нээлтийн арга хэмжээг 2017.10.11-нд зохион байгуулж зорилтот бүлгийн ажилгүй, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэдийг дадлагажуулан шинэ мэргэжил, ур чадвар эзэмшүүлэх, мэргэшүүлэх зорилгоор “Төмөр замын замчин” мэргэжлээр чадамжид суурилсан сургалтыг амжилттай зохион байгууллаа. Сургалтаар төмөр замын ерөнхий зохион байгуулалт, техник ашиглалтын дүрэм, замын бүтэц, төмөр замын хиймэл төхөөрөмж байгууламж, түүний арчилгаа, төмөр замын ажлын технологи, дохиоллын болон галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журмын талаар мэдлэг олгож, дадлагыг төмөр замын үндсэн аж ахуйн нэгжүүд дээр замчны хөдөлмөрийн аюулгүй байдалтай танилцах хэлбэрээр зохион байгуулсан.



САЛБАРЫН ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН АЖИЛТНУУД ЗЭРЭГ ГОРИЛОХ ШАЛГАЛТДАА АМЖИЛТТАЙ ОРОЛЦЛОО

Төмөр замын тээврийн салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөлийн хурлаар салбарын мэргэжилтэнд мэргэжлийн зэрэг олгоход тавигдах шаардлага хангасан инженерүүдийн мэргэжлийн шалгалтын дүн болон бүтээлийн тайланг хэлэлцсэн шийдвэрийг ЗТХЯ-нд хүргүүлснээр Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар мэргэжлийн зэрэг шинээр олгосон болон сунгасан 7 мэргэжилтэнд батламж, гэрчилгээ, мэргэшсэн, зөвлөх инженерийн тэмдэг олголоо.



Аравдугаар сар 2017 он

СУУРЬ БҮТЦИЙН 2017 ОНЫ 9-Р САРЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ЗУРМАГИЙН ТАСАЛДЛЫН ТАЙЛАН

“УБТЗ” ХНН-ийн галт тэргэний хөдөлгөөний 2017 оны 9-р сарын галт тэргэний хөдөлгөөний зурмагийн тасалдлын мэдээг авч үзэхэд: 2017 оны 9-р сард нийт 132 тасалдал гарч, галт тэргэний 179,6 цагийн барилт үүссэн байна. Өмнөх сарын тасалдлын тоо, галт тэргэний цагийн барилт, хохирлын хэмжээтэй харьцуулахад:

Тасалдлын хэмжээ, тоо




График №3

Галт тэргэний цагийн барилт, цаг






График №4

Өмнөх сараас тасалдлын хэмжээ 23-н нэгж буюу 14,8%-иар багасч, галт тэргэний цагийн барилт 9,4-н цаг буюу 5,5%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Зурмагийн тасалдлын тоо болон тасалдлаас үүссэн хохирлын шалтгааныг үзэхэд: Нийт тасалдлын 71-н тасалдал буюу 53,79%-ийг техникийн эвдрэл, 43-н тасалдал буюу 32,58%-ийг технологийн зөрчил, 18 буюу 13,64%-ийг бусад шалтгаан эзэлж байна.



Диаграмм №1



Диаграмм №2

Нийт тасалдлын 110 нэгж буюу 83,3%-ийг УБТЗ ХНН, 11 нэгж буюу 8,3%-ийг Эрэн өртөө, 1 нэгж буюу 0,76%-ийг Наушки өртөө, 10 нэгж буюу 7,58%-ийг бусад шалтгаан эзэлж байна.



Аравдугаар сар 2017 он

ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИК МЭДЭЭ

Төмөр замын тээврийн салбарын статистик, мэдээ, мэдээллийг нэгтгэж, нийгэм, эдийн засгийн байдалд нөлөөлсөн байдлаар дүн шинжилгээ хийх, төвийн цахим хуудаст зураг, график хэлбэрээр мэдээлэл байршуулж олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг <http://rtcc.mrtd.gov.mn/> хаягаар орж танилцана уу.



ТӨВИЙН АЖИЛТНУУД ЦУСНЫ ДОНОРЫН ЭГНЭЭНД НЭГДЛЭЭ

Цус сэлбэлт, судлалын үндэсний төвөөс зохион байгуулдаг “Сар бүрийн 3- Цусаа бэлэглэх” сайн үйлсийн аянд Төвийн ажилтнууд нэгдэж цусаа бэлэглэлээ. Нэг хүн цусаа бэлэглэхэд 3 хүний амь авардаг тул “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ-ын хамт олны зүгээс энэхүү сайн үйлсийн аянд та бүхнийг нэгдэхийг уриалж байна. Цусаа бэлэглэж бие биендээ амьдрал бэлэглэе!

